

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

НИЙЛҮҮЛЭГЧ

ЧАТБОТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭНХЧУЛУУН



**“Тусгай зөвшөөрлийн нэгдсэн програм хангамж датабаз хөгжүүлэх”**

**ХХЗХ/202112014 тоот тендерийн гэрээ.**

**Дугаар № ХХЗХ/202112014**

Улаанбаатар хот

Нэг талаас *Харилцаа холбооны зохицуулах хороо* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *Чатбот ХХК* (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 7 сарын 6 -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1 -д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь **“Тусгай зөвшөөрлийн нэгдсэн програм хангамж датабаз хөгжүүлэх” ХХЗХ/202112014** -г (цаашид “ажил” гэх) **183,537,500 төгрөг (нэг зуун наян гурван сая таван зуун гучин долоон мянга таван зуун төгрөг)** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт

Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ

Хавсралт №2 Ажил Гүйцэтгэлийн хуваарь болон Тайлан гаргах хуваарь


Хавсралт №3 Голлох мэргэжилтний ажлын хуваарь

Хавсралт №4 Ашиглалт үйлчилгээний төлөвлөгөө, үнийн санал

Хавсралт №5 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.



7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЗУХАГ-ын дарга З.Эрдэнэчулуун



ЗУХАГ, ХАХХ-ийн дарга  
Б.Мягмарнаран



Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн  
Ц.Бүрэнжаргал



Метро бизнес төв А корпус 5 давхар  
Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-14201 0033 Утас:11-304258  
Факс:327720

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Чатбот ХХК Дэд захирал Б.Цогтсайхан


Монгол улс, Улаанбаатар хот, Баянгу  
дүүрэг, 16-р хороо, Колорадо бизнес те  
202 тоот

Утас: 77441616

Голомт банк: 1415126872 (Чатбот ХХК)

